



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 8 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 327

Улаанбаатар
хот

Концессын гэрээ байгуулах
эрх олгох тухай

Концессын тухай хуулийн 6.1.2, 19.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх “Эрдэнэт хотоос Овоотын уурхай чиглэлийн төмөр зам төсөл”-ийн концессын гэрээг “Нортерн Рэйлвэйс” ХХК-тай байгуулах эрхийг Хөрөнгө оруулалтын газарт олгож, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгасугай.

2. Концессын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрөл болон бусад шаардлагатай зөвшөөрлийг олгох, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг батлах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Зам, тээврийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд нарт тус тус даалгасугай.

3. Шинээр барих төмөр замын суурь бүтцийг “Улаанбаатар төмөр зам”-ын эзэмшлийн суурь бүтэцтэй холбох чиглэлээр концесс эзэмшигч болон Монгол, Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын хооронд гэрээ байгуулах ажилд хяналт тавьж, холболт хийх ажлыг зохион байгуулан ажиллахыг Зам, тээврийн сайд болон Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Аж үйлдвэрийн сайд

Д.ЭРДЭНЭБАТ